



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамс,
3 дугаар байр, Сайншалан сум, Дорноговь аймаг, 44100,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovis@audit.gov.mn

2022.02.24 № А-6/226

танай _____-ны № _____-т

**АЛТАНШИРЭЭ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.УРАНЧИМЭГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй

0100049

үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 18.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 191.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 109.2 сая төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47.1 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.0 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 1.3 сая төгрөгийн 1 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл "16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг." заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Тайлант онд өглөг, авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй. Мөн тухайн зөрчилд өмнөх оны аудитаар албан шаардлага өгөгдсөн ч биелэлт хэрэгжээгүй, тайлант онд дахин давтагдсан байна. Энэ нь тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд МУЕА-ын 2020 оны А/95 тоот тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйл Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 12.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 13 зорилт, 37 арга хэмжээний хэрэгжилт 94.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 92.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,352,533.02	85,998,944.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	18,554,594.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	18,554,594.00
3121	Төгрөг	-	18,554,594.00
31211	Төрийн сангийн харилцах	-	15,315,947.00
31213	Ахмадын сан харилцах	-	3,238,647.00
33	АВЛАГА	150,695.00	30,695.00
335	Бусад авлага	150,695.00	30,695.00
3351	Байгууллагаас авах авлага	150,695.00	30,695.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,201,838.02	67,413,655.02
351	Түүхий эд материал	22,176,181.00	23,040,845.00
35110	Тусгай зориулалттай материал	22,176,181.00	23,040,845.00
354	Хангамжийн материал	37,025,657.02	44,372,810.02
35410	Бичиг хэргийн материал	1,202,588.00	1,100,690.00
35420	Аж ахуйн материал	26,424,550.02	27,821,147.02
35440	Түлш, шатах тослох материал	208,100.00	130,295.00
35460	Хүнсний материал	8,328,461.00	14,458,720.00
35470	Бусад хангамжийн материал	861,958.00	861,958.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	767,120,680.13	731,702,159.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	767,120,680.13	731,702,159.34
392	Биет хөрөнгө	763,929,080.17	728,580,959.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	701,800,793.00	701,800,793.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,651,871.64)	(18,388,551.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,484,118.00	54,969,218.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,888,222.45)	(36,745,669.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,620,642.08	30,983,254.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,491,960.70)	(20,467,504.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,967,120.00	25,967,120.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,038,370.15)	(11,941,286.34)
39217	Ном	3,126,832.03	2,403,585.38
393	Биет бус хөрөнгө	3,191,599.96	3,121,199.92
39301	Програм хангамж	462,000.00	462,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(180,400.04)	(250,800.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,910,000.00	2,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	826,473,213.15	817,701,103.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	911,751.00	720,126.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	911,751.00	720,126.00
413	Өглөг	911,751.00	720,126.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	614,214.00	657,389.00
4136	Бусад өглөг	297,537.00	62,737.00
41361	Байгууллагад төлөх өглөг	25,000.00	25,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	272,537.00	37,737.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	825,561,462.15	816,980,977.36
51	Засгийн газрын хувь оролцоо	825,561,462.15	816,980,977.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,488,433.00	52,488,433.00
512	Хуримтлагдсан үр дүн	773,073,029.15	764,492,544.36
51210	Өмнөх үеийн үр дүн	773,073,029.15	773,311,676.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,819,131.79)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	826,473,213.15	817,701,103.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	951,611,026.00	255,560,153.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	731,031,493.00	2,413,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	731,031,493.00	2,413,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,513,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,513,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,332,700.00	900,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	727,698,793.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,579,533.00	253,146,353.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	189,896,000.00	206,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,838,200.00	206,477,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	174,057,800.00	-

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,563,533.00	46,669,153.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,563,533.00	46,669,153.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	218,673,638.41	262,473,047.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,673,638.41	262,473,047.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,610,911.41	262,473,047.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,010,916.00	152,967,934.00
210101	Үндсэн цалин	86,066,202.00	121,597,446.00
210102	Нэмэгдэл	38,632,583.00	26,617,767.00
210104	Урамшуулал	10,312,131.00	4,752,721.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,537,994.00	19,291,613.00
210201	Тэтгэврийн даатгал	12,514,294.00	12,643,413.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,255,900.00	1,545,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,022,800.00	1,460,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	233,200.00	317,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,511,800.00	3,324,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,263,533.00	31,667,324.00
210301	Гэрэл, цахилгаан	2,053,665.00	2,903,064.00
210302	Түлш, халаалт	27,160,716.00	27,094,636.00
210303	Цэвэр, бохир ус	1,049,152.00	1,669,624.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,104,000.00	2,879,307.00
210401	Бичиг хэрэг	523,800.00	808,998.00
210402	Тээвэр, шатахуун	981,900.00	263,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	133,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	189,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,107,000.00	469,470.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	168,800.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	1,337,239.00
2105	Нормативт зардал	8,277,749.00	17,412,086.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	184,600.00	-
210502	Хоол, хүнс	7,793,149.00	17,412,086.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	515,900.00
210604	Урсгал засвар	-	515,900.00
2107	Томилолт, зочны зардал	248,000.00	-
210702	Дотоод албан томилолт	248,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	436,000.00	344,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	344,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,732,719.41	37,394,383.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,662,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	157,200.00	1,219,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	21,575,519.41	33,512,283.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,062,727.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,050,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,050,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,012,727.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,727.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	732,937,387.59	(6,912,894.47)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	59,176,845.02	1,906,237.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	59,150,400.56	1,137,657.31
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал -Үндсэн хөрөнгө	26,444.46	768,580.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(59,176,845.02)	(1,906,237.32)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	673,760,542.57	(8,819,131.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	220,579,533.00	255,018,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,752,447.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,752,447.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,752,447.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,513,800.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	238,647.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	220,579,533.00	253,266,353.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	189,896,000.00	206,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,838,200.00	206,477,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	174,057,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,000.00	120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,000.00	120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,563,533.00	46,669,153.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,563,533.00	46,669,153.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	201,177,333.00	236,464,206.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201,177,333.00	236,464,206.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,994,606.00	236,464,206.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,592,660.00	152,924,759.00
210101	Үндсэн цалин	83,498,560.00	121,554,271.00
210102	Нэмэгдэл	36,781,969.00	26,617,767.00
210104	Урамшуулал	10,312,131.00	4,752,721.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,783,975.00	19,291,613.00
210201	Тэтгэврийн даатгал	11,760,275.00	12,643,413.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,255,900.00	1,662,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,004,800.00	1,344,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	251,200.00	317,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,511,800.00	3,324,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,263,533.00	31,667,324.00
210301	Гэрэл, цахилгаан	2,053,665.00	2,903,064.00
210302	Түлш, халаалт	27,160,716.00	27,094,636.00
210303	Цэвэр, бохир ус	1,049,152.00	1,669,624.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,306,500.00	-
210401	Бичиг хэрэг	716,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	153,400.00	-
210404	Ном, хэвлэл	35,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	-
2105	Нормативт зардал	10,127,140.00	23,707,645.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	141,600.00	-
210502	Хоол, хүнс	8,985,540.00	23,707,645.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,052,100.00	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,230,700.00	-
210602	Тавилга	521,400.00	-
210604	Урсгал засвар	300,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	248,000.00	-
210702	Дотоод албан томилолт	248,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	436,000.00	317,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	317,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,184,698.00	7,055,865.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,862,365.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,184,698.00	2,193,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,182,727.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,050,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,050,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,000.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	120,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,012,727.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,727.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,402,200.00	18,554,594.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,564,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,564,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	3,564,000.00	-
223001	Бусад хөрөнгө	3,564,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,564,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,838,200.00	18,554,594.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,554,594.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуриртлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,488,433.00	17,229,094.62	97,921,591.96	167,639,119.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,229,094.62	17,229,094.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,488,433.00	17,229,094.62	115,150,686.58	184,868,214.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(17,229,094.62)	-	(17,229,094.62)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	657,922,342.57	657,922,342.57
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,488,433.00	-	773,073,029.15	825,561,462.15
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	52,488,433.00	-	773,073,029.15	825,561,462.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	238,647.00	238,647.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,488,433.00	-	773,311,676.15	825,800,109.15
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,819,131.79)	(8,819,131.79)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,488,433.00	-	764,492,544.36	816,980,977.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	254,977,300.00	236,464,206.00	18,513,094.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,977,300.00	236,464,206.00	18,513,094.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,977,300.00	236,464,206.00	18,513,094.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,202,400.00	152,924,759.00	13,277,641.00
210101	Үндсэн цалин	136,948,400.00	121,554,271.00	15,394,129.00
210102	Нэмэгдэл	26,059,900.00	26,617,767.00	(557,867.00)
210104	Урамшуулал	3,194,100.00	4,752,721.00	(1,558,621.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,732,300.00	19,291,613.00	1,440,687.00
210201	Тэтгэврийн даатгал	14,097,900.00	12,643,413.00	1,454,487.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,658,600.00	1,662,100.00	(3,500.00)
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,326,900.00	1,344,300.00	(17,400.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	331,800.00	317,800.00	14,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,317,100.00	3,324,000.00	(6,900.00)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,214,100.00	31,667,324.00	1,546,776.00
210301	Гэрэл, цахилгаан	3,450,000.00	2,903,064.00	546,936.00
210302	Түлш, халаалт	27,514,100.00	27,094,636.00	419,464.00
210303	Цэвэр, бохир ус	2,250,000.00	1,669,624.00	580,376.00
2105	Нормативт зардал	25,375,400.00	23,707,645.00	1,667,755.00
210502	Хоол, хүнс	25,375,400.00	23,707,645.00	1,667,755.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,000.00	317,000.00	127,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444,000.00	317,000.00	127,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,509,100.00	7,055,865.00	453,235.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,259,100.00	4,862,365.00	396,735.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,193,500.00	56,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,977,300.00	255,018,800.00	(41,500.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	206,477,200.00	206,477,200.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	206,477,200.00	206,477,200.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,216,100.00	46,669,153.00	1,546,947.00
132001	Орон нутгийн төсвөөс	48,216,100.00	46,669,153.00	1,546,947.00
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	-	120,000.00	(120,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	120,000.00	(120,000.00)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	284,000.00	1,752,447.00	(1,468,447.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	284,000.00	1,513,800.00	(1,229,800.00)
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	238,647.00	(238,647.00)

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		18,554,594.00	(18,554,594.00)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	120,000.00
213305	Нэмэлтийн үлдэгдэл шилжүүлэг		120,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	120,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	120,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		120,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38.5 сая төгрөгийн 7 алдаа¹ илэрснээс аудитын явцад 38.5 сая төгрөгийн 7 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа тавигдаагүйгээс 1.7 сая төгрөгөөр элэгдэл дутуу байгуулсныг ;
2. Санхүү байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эхний болон эцсийн үлдэгдэлтэй 28.5 сая төгрөгөөр зөрүүтэй, мөн орлого үр дүнгийн тайлангаарх элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын элэгдлийн зардлаас 4.8 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг;
3. Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн ахмадын сангийн 3.0 сая төгрөгийн гүйлгээг орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэснийг;
4. Ахмадын сан дансны оны эхний 0.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг бүртгээгүй байсныг;
5. Санхүү байдлын тайлангийн тайлант оны ашиг нь үр дүнгийн тайлангийн тайлант оны ашгаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг;
6. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нийт дүнгээр, иж бүрдлээр ирүүлээгүй, мөн нэмэлт санхүүжилтийн тайлан ирүүлээгүй байсныг;
7. Орж ирсэн 0.1 сая төгрөгийн авлагыг орлого үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрснээс 1.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 7 дугаар сард үндсэн цалингийн 41 хувь, 8 дугаар сард 41 хувь, 10 дугаар сард 27 хувь, 12 дугаар сард 41.9 хувиар буюу нийт 1.7 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 191.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 109.2 сая төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47.1 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.0 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 1.3 сая төгрөгийн 1 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Өр, авлагатай холбоотой асуудал

Тайлант онд өглөг, авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй. Мөн тухайн зөрчилд өмнөх оны аудитаар албан шаардлага өгөгдсөн ч биелэлт хэрэгжээгүй, тайлант онд дахин давтагдсан байна. Энэ нь үнэн бодит мэдээллээр хангагдахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Мөн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд МУЕА-ын 2020 оны А/95 тоот тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйл Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 12.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа тавигдаагүй, 1.7 сая төгрөгөөр элэгдэл дутуу байгуулсан	1	1,738.1	0	-	1	1,738.1	1	1,738.1				
Санхүү байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдэл нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын эхний болон эцсийн үлдэгдэлтэй 28.5 сая төгрөгөөр зөрүүтэй, мөн орлого үр дүнгийн тайлангаарх элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын элэгдлийн зардлаас 4.8 сая төгрөгөөр зөрүүтэй.	1	33,367.7	0	-	1	33,367.7	1	33,367.7				
Ахмадын сангийн мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн 3.0 сая төгрөгийн гүйлгээг орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэсэн	1	3,000.0	0	-	1	3,000.0	1	3,000.0				
Ахмадын сангийн оны эхний мөнгөн хөрөнгө 0.2 сая төгрөгийг бүртгээгүй	1	238.6	0	-	1	238.6	1	238.6				
Санхүү байдлын тайлангийн тайлант оны ашиг нь үр дүнгийн тайлангийн тайлант оны ашгаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй	1	240.0			1	240.0	1	240.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайлан нийт дүнгээр, иж бүрдлээр ирүүлээгүй, мөн нэмэлт санхүүжилтийн тайлан ирүүлээгүй	1				1		1					
Орж ирсэн 0.1 сая төгрөгийн авлагыг орлого үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн	1	120.0			1	120.0	1	120.0				
Дүн	7	38,704.4	-	-	7	38,704.4	7	38,704.4	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант онд өглөг, авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй. Мөн тухайн зөрчилд өмнөх оны аудитаар албан шаардлага өгөгдсөн ч биелэлт хэрэгжээгүй, тайлант онд дахин давтагдсан байна.	1									1			
Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 12.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1							1					
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 7 дугаар сард үндсэн цалингийн 41 хувь, 8 дугаар сард 41 хувь, 10 дугаар сард 27 хувь, 12 дугаар сард 41.9 хувиар буюу нийт 1.7 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	1,689.3	1	1,689.3									
Дүн	4	1,689.3	1	1,689.3				1		1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 191.4 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 109.2 сая төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47.1 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18.0 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 1.3 сая төгрөгийн 1 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
Дүн	1		-	-	1	-		